



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/677

Ховд

Оюу мандлын орон сууцны барилгын дулааны шугам сүлжээний засварын ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Цацаг” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Оюу мандлын орон сууцны барилгын дулааны шугам сүлжээний засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Н.Цацралцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Р.Янжмаа - Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цолмонбаатар - Стандарт, хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Г.Тунгалаг - Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

Ц. Бэхбаяр - Магсаржав багийн нийгмийн ажилтан

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга

Б.Бямбажав - “Цацаг” ХХК-ийн захирал